

талаар улсын эдийн засагт тодорхой хэмнэлт, үр ашгийг бий болгох

-Бүтээн байгуулалтын ажилд оролцож болох чиглэлийн талаар судалгаа хийх

-Гэм хорын хохирлыг тэдний хөдөлмөрийн хөлснөөс нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх

-Ялтныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэлбэр нь хөдөлмөрийн хүмүүжил буюу хөдөлмөрийн дадлага чадвар олгох явдал юм. Хөдөлмөр эрхэлснээр ажлын эв дүй, арга ухаан, тэсвэр хатуужил, хамт олны дунд биеэ зөв авч явах дадал хэвшил суухаас гадна суллагдан гарсны дараа нийгэмд эзлэх байр сууриа олоход дөхөм болно. Үүний тулд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь ШШГБ-ын менежментийн шинэчлэлийн нэг чухал асуудал юм.



Г.БАТТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛЛЫН ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдсэн үндэстний байгууллагаас 1948 онд батласан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд: “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хамгаалуулах эрхтэй”⁹⁶ гэж заажээ.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан⁹⁷.

⁹⁶ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/>

⁹⁷ М.Ичинноров. “Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах тогтолцоо бий болж байгаа нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн” Хууль сахиулахын инноваци олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл <http://ichinnorovm.blogspot.com/2014/11/blog-post.html>

Иймд хүний эрхийн хамгаалалт нь төрийн зорилго, чиг үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой⁹⁸ билээ. Нөгөө талаас хүний эрхийн асуудал нь улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л салбартай шууд холбоотой учир Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил, хууль, хяналтын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулж, хамтран ажилласнаар гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх, тодорхой үр дүнд хүрэх бололцоотой юм.

Олон улсын байгууллагын гаргасан статистикийн мэдээнээс үзэхэд дэлхий дээр дөрвөн гэрчийн нэг нь байцаан шийтгэх ажиллагааны явцад өөрийн мэдүүлгээс буцдаг байна⁹⁹. Тиймээс гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад хэргийн бодит үнэнийг тогтоох, түргэн шуурхай илрүүлэхэд бэрхшээл учирч, хамгийн нягт нямбай мөрдсөн хэрэг ч эцсийн дүндээ үр дүнгүй болох нь ч бий.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан Авилгалын эсрэг конвенци, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид “Оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон,

буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж тус тус үүрэг хүлээлгэсэн байна.

Үүнээс үүдэлтэйгээр ихэнх хөгжилтэй улс орнуудад гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах янз бүрийн хөтөлбөрийг олон арван жилийн турш хэрэгжүүлсээр иржээ. Өөрөөр хэлбэл тэдгээр улс орнуудад эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд гэрч, хохирогчийн хувийн аюулгүй байдал, түүнийг хамгаалах асуудал эрх зүйн тогтолцооных нь нэг чухал хэсэг болон бүрэлдсэн гэж үзэж болно. Тухайлбал АНУ, Англи, Герман, Австрали, Итали, Канад зэрэг улсуудын гэрч, хохирогчийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг үзэхэд гэрч хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтыг бүрдүүлснээс гадна хөрөнгө санхүү, зохион байгууллалтын арга хэмжээг цогц байдлаар нь тусгасан тусгай хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж, энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулж байна.

Ер нь олон улсын түвшинд хохирогчид дэмжлэг (victim support), гэрчид хамгаалал (witness protection) гэсэн үндсэн зарчим үйлчилдэг.

Гэрч гэж хэн бэ? Гэсэн асуултанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал, улс орнуудын эрх зүйн

⁹⁸ Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ.. 2004. 407-р тал

⁹⁹ Т.Оюунчимэг. Гэрч. УБ.. 2014. 33 дахь тал

тогтолцооноос шалтгаалан харилцан адилгүй утгаар хариулах боловч гэмт хэргийн гэрчийн талаарх хууль зүйн болон судлаачдын тодорхойлолтод “хэргийн талаар шүүхээс үнэн зөв, шударга, үндэслэл бүхий шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа, тэр талаар үнэн зөв мэдүүлэх чадвартай хэн ч гэрч байж” болно гэсэн нийтлэг шинжүүдийг агуулсан байна¹⁰⁰.

Хамгаалалтын зорилгын хувьд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх, шүүн таслах ажиллагаанд тухайн хэргийн талаар чухал ач холбогдол бүхий, үнэ цэнэтэй мэдээллийг мэдэж байгаа хүнийг мэдээллийн эх сурвалжын хэмжээнд үнэлэх бус иргэний үүргээ биелүүлж шударга шүүхийн өмнө үнэн зөв мэдүүлэг өгч буй иргэний хувьд үнэлж, түүнийг хамгаалах олон улсын чиг хандлага, арга хэмжээ улам чухлаар тавигдах болсон.

Харин НҮБ-ын 1985 оны “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай” тунхаглалын гэмт хэргийн хохирогч гэсэн ойлголтод “...эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие махбодийн болон оюун санаа, эд хөрөнгийн хохирол учирсан, сэтгэл санааны дарамтанд орсон, эсхүл үндсэн эрх нь ноцтой зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно”¹⁰¹ гэж заажээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал олон улсын шинж чанартай болохын хэрээр гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг шаардаж байна. НҮБ болон олон улсын бусад байгууллагуудаас батлан гаргасан баримт бичгүүдийн үзэл санааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улс орнууд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар ихээхэн анхаарах болсон. Ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд энэ нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд барууны гэгдэх өндөр хөгжилтэй улсууд тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, тусгайлсан хууль тогтоомжийг батлан гаргах замаар гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бий болгосон байна. Ийм тогтолцоог бүрдүүлэн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй зарим улс орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

Америкийн Нэгдсэн Улс

Гэрч хамгааллын асуудал нь анх 1970-аад оны дунд үеэс Америкийн нэгдсэн улсад Мафи буюу гэмт бүлэглэлүүдийг устгах хөтөлбөрийн хүрээнд хөндөгдөж байжээ. Тухайн цаг үеийг хүртэл Omerta буюу Мафийн гишүүдийн дунд “Чимээгүй байх” гэсэн бичигдээгүй хууль ноёрхож байсан бөгөөд цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан, гэмт бүлэглэлийн хууль бус үйлдлийн

¹⁰⁰ Т.Оюунчимэг. Гэрч. УБ., 2014. 18-20 дахь тал

¹⁰¹ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ., 1996 174 дэх тал

талаар мэдээлэл өгөх гэсэн хэнийг ч үхлээр заналхнийлж байв.

Энэ байдлаас шалтгаалаад гэрчүүд гэмт хэргийн талаар мэдүүлэг өгөхөөс татгалзах, хэргийг мөрдөн шалгах, бодит үнэнийг тогтооход ихээхэн хүндрэл гарах болжээ. Иймд АНУ-н Конгресс зохион байгуулалттай гэмт хэргийн гэрчийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхийг Хууль зүйн яаманд олгож “Зохион байгуулалттай гэмт хэрэгт тавих хяналтын тухай” хууль баталсан¹⁰² цагаас гэрч хамгаалалын тогтолцоо бүрдэж эхэлсэн гэж үздэг. Улмаар 1982 онд Конгресс гэмт хэргийн “Гэрч, хохирогчийн хамгаалалах акт”¹⁰³ (The Victim and Witness Protection Act), 1984 онд “Гэрчийн аюулгүй байдлыг сайжруулах акт”¹⁰⁴ (Witness Security Reform Act) – ыг тус тус батлан гаргасан байна. Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг Холбооны Маршалуудын алба хэрэгжүүлдэг.

Гэрч, хохирогчдыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойшх 30 гаруй жилийн хугацаанд 7000 гаруй гэрч, хохирогч, тэдний гэр бүлийн 9000 гаруй гишүүд “засгийн газартай хэлцэл” хийж маршалын албаар хамгаалуулан төрийн хамгаалалтанд орсон мэдээ бий¹⁰⁵. Бусад улс орны хууль тогтоогчид АНУ-ын конгрессоос баталсан хууль, засгийн газраас авч хэрэгжүүлсэн гэрч,

хохирогчийг хамгаалах хөтөлбөрүүдээс баримжаа авч өөрсдийн онцлогт тохируулан эрх зүйн актуудыг батлан гаргах, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлыг эхлүүлсэн байдаг.

Өнөөдөр АНУ-ын муж улс бүрт гэрч, хохирогчийг хамгаалах талаар хууль тогтомжийг батлан хэрэгжүүлж байна.

Гэрчийг хамгаалалтанд авахын өмнө гэрчтэй хэлцэл хийхээр хамгаалалтанд авах гэж буй эрх бүхий субъектээс гэрчид “харилцан ойлголцох тухай санамж бичиг” (memorandum of understanding) илгээх бөгөөд түүнд хамгаалах арга хэмжээг, хэрэглэх нөхцлийг тусгана. Тухайлбал гэрч нь гэм буруутай этгээдийг илчлэх, гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий мэдээлэл өгвөл аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ хэрэглэх талаар тодорхой заадаг. Мөн хамгаалуулах гэж буй этгээд санамж бичигт заасан нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг өөрчлөх талаар тусгадаг байна.

АНУ-ын хорих байгууллагууд гэмт хэргийн хохирогчтой идэвхтэй хамтран, тэднийг дэмжин ажилладаг бөгөөд ялтныг хугацнаас өмнө суллах талаар асуудлыг шийдвэрлэхдээ тухайн этгээдийн хохирогчийн саналыг Тусгай комисс буюу Пароул комиссоор (Parole Commission/Board) дамжуулан нууцаар авах ба хохирогч ялтныг сулласан нөхцөл, хугацааны тухай мэдээллийг мөн бичгээр авдаг.

Австрали улс

Анх 1983 онд Хааны комиссоос Австралид зохион байгуулалттай гэмт

¹⁰² Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 490 дэх тал.

¹⁰³ www.justice.gov/usao-wdla/programs/victim-witness

¹⁰⁴ <https://www.justice.gov/usam/usam-9-21000-witness-security>

¹⁰⁵ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 491 дэх тал.

хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлсэн бөгөөд гэмт бүлэглэлийн зохион байгуулагчид, толгойлогчдын талаар мэдээлэл өгсөн, гэмт бүлэглэлийн гар хөл бологсод буюу доогуур байр эзэлдэг гишүүдэд боломж олгох талаар хөндсөн байдаг.

Энэхүү арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд зохион байгуулалттай гэмт хэргийг илчлэхэд тусалсан, мэдүүлэг өгсөн, хамтарч ажилласан хүнийг цагдаагийн байгууллага 24 цагийн турш хамгаалалтанд авч, тэдний бичиг баримтыг солих, нүүлгэн шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн юм.

1988 онд парламентын хамтарсан хороо нэгэн дэлгэрэнгүй судалгаан дээр үндэслэн гэрч хамгааллын асуудлын талаар хэлэлцсэн бөгөөд энэхүү хэлэлцүүлгийн тайлан 2 чухал шийдвэр гаргахад нөлөөлжээ.

1. Гэрч хамгаалах тухай 1994 оны хуулийг батлан гаргаж гэрч хамгааллын тогтолцоог Хамтын нөхөрлөлийн орнуудын (Commonwealth level) түвшинд хүргэсэн

2. Австралийн үндсэн бүс нутаг болон хэд хэдэн мужуудад тухайн хуулийн дагавар хуулиуд батлагдахад хүргэсэн гэж үздэг. Уг хууль батлагдсанаар үндэсний хэмжээний гэрч хамгаалах хөтөлбөр хэрэгжиж, гэмт хэргийн гэрч олон хүн үүнд хамрагдах боломж бүрэлдсэн. Гэрч хамгаалах тухай хууль 1997, 2002 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт орж

улам боловсронгуй болон мөрдөгдөж байна¹⁰⁶.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Гэрч хамгаалах хөтөлбөр 1980 оноос хойш Германд хэрэгжиж эхэлсэн гэж үздэг. Тухайлбал мотоциклын бүлэглэлээс (Bikers) үйлдэгдэж буй зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор Гамбург хотын цагдаагийн газраас хэргийг илрүүлэх, мөрдөн шалгалт явуулахад хамтарч ажилласан, гэмт хэргийн талаар үнэтэй мэдээлэл өгсөн гэрчүүдийг хамгаалах анхны арга хэмжээ авчээ. Энэхүү хөтөлбөрийг баримжаа болгон Холбооны Эрүүгийн цагдаагийн газраас гэрч хамгаалах ажиллагааг бүх Герман даяар системтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн байна.

ХБНГУ Гэрч хамгаалах тухай бие даасан хуулиа 1998 онд баталсан юм. Тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Германы ЭБШХ-д гэрчийг байцаахтай холбоотой шинэ заалт орсон байна. Мөн 1998 онд гэрчийг хамгаалах тусгай чиг үүрэг бүхий Эрүүгийн цагдаагийн тусгай хэсэг анх байгуулж, гэрч хамгаалах газартай хамтран заавар боловсруулан тусгай хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ.

Эрсдэлд буй гэрчийг хамгаалах тухай хууль 2001 онд батлагдах хүртэл гэрч хамгаалах заавар Германы гэрчийг хамгаалах хөтөлбөрийн гол үндэс баримт бичиг болж байв. Энэ үеэс

¹⁰⁶ Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008., page 9. <https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

ХБНГУ-ын гэрчийг хамгаалах хөтөлбөр эрчимтэй хэрэгжиж холбооны түвшинд болон муж улс бүрт гэрч хамгаалах газар байгуулагдсан.

Улмаар Холбооны Эрүүгийн цагдаагийн газраас улс орны хэмжээнд мөрдөн шалгаж буй бүх хэргийн гэрчийг хамгаалах төдийгүй муж улсуудын болон олон улсын хэмжээнд гэрч хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах үүргийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал Гэрч хамгаалах хөтөлбөрийн жилийн тайланг бэлтгэн гаргах; гэрч хамгаалах талаар сургалт, сурталчилгаа явуулах; холбооны болон муж улсын гэрч хамгаалах албаны захирлуудын ээлжит бага хурлыг зохион байгуулах; бусад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа тогтоон хамтран ажиллах; олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг үндсэн үүргийг хэрэгжүүлдэг¹⁰⁷.

Өмнөд Африкийн бүгд найрамдах улс

Өмнөд Африкт гэрч хамгаалах үйл ажиллагаа нь 1996 оны Гэмт Хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний стратегийг батлагдах хүртэл 1977 оны Гэмт хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж байсан. Гэрч хамгаалахтай холбоотой заалтууд нь ерөнхийдөө албадлагын шинж чанартай байсан бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах дэглэмийн үед гэрчээс мэдүүлэг, нотлох баримт

гаргаж өгөхөд албадлага хэрэглэж байв.

1996 оны Өмнөд Африкийн парламентад тус улсын засгийн газрын тавьсан тайланд аюул занал, халдалгад өртөж болзошгүй гэрчүүдээс мэдүүлэг авах, тэдний гаргасан нотлох баримтыг хамгаалах, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд гэрч хамгааллын асуудал чухал болохыг ойлгуулсан бөгөөд тухайн үед гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд гэрчийг хамгаалах ажиллагаа хангалтгүй байгааг хууль тогтоогчид хүлээн зөвшөөрсөн байна.

Иймд Өмнөд Африкийн парламентаас Гэрч хамгаалах тухай хуулийг 2000 онд эцэслэн баталснаар өмнөх тогтолцоог бүр мөсөн өөрчилж гэрч, хохирогчийг хамгаалах шинэ тогтолцоог бий болгож чадсан байна. Үүний үр дүнд ӨАБНУ-д гэрч, хохирогч хамгаалах олон хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсээр иржээ.

Бүгд найрамдах Итали улс

Итали орон эртнээс зохион байгуулалттай гэмт бүлэглэл буюу “мафигаар” алдартай гэдгийг бид мэднэ. Мафитай хийх тэмцлийг амжилттай хэрэгжүүлэх нь үе үеийн засгийн газрын өмнө томоохон асуудал болсоор ирсэн. Ийм ч учраас судлаачид гэрч, хохирогчийг хамгаалах Италийн хөтөлбөр нь дэлхийн хамгийн эртний хөтөлбөрийн нэг гэж үздэг.

Итали улсад гэрчийг хамгаалах асуудал нь терроризм болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд бий болжээ. Гэрчийг хамгаалах хөтөлбөр 1984 онд албан ёсоор хэрэгжих эхлэл нь тавигдсан гэж

¹⁰⁷ Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008., page 12. <https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

үздэг. Энэ нь тухайн үеийн гэмт бүлэглэлийн гишүүн байсан Томмаза Бушетта мафийн томоохон бүлэглэлийн эсрэг мэдүүлэг өгч үүний үр дүнд гэмт бүлэглэлийн толгойлогч, гишүүд нийт 350 хүнийг илчлэн, баривчилж шоронд хорьсноос үүдэлтэй. Бушеттаг мэдүүлэг өгсний дараа түүнийг хамгаалалтанд авч улмаар бичиг баримт болон гадаад төрхийг өөрчлөх зэрэг хамгаалалтын арга хэмжээг авсан байна.

1988 онд баталсан “Мафиудаас үйлдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах талаар авч хэрэгжүүлэх хойшлуулашгүй арга хэмжээний тухай” №726 хуулиар мафийн эсрэг хамтран ажилласан буюу тэдний үйл ажиллагаатай холбоотой баримт, сэлтийн тухай мэдүүлэг өгсний улмаас ноцтой аюулд учирч байгаа этгээдийг хамгаалалтанд авч, шаардлагатай бүх арга хэмжээг хэрэглэж байх зөвшөөрлийг мафитай тэмцэх комиссараас зохих эрх бүхий байгууллагад өгч байхыг зөвшөөрсөн байдаг¹⁰⁸.

Энэхүү үйл явдлын үр дүнд 1990-ээд оны эцэст гэмт бүлэглэлийн 1000 гаруй гишүүд зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэхэд хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан ба томоохон үр дүнд хүрчээ¹⁰⁹. Гэсэн хэдий ч Италийн гэрч

хамгаалах хөтөлбөр нь гарал үүсэл, сонгосон арга барил болон гэрчийг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилт, удирдлага зохион байгуулалт буруу байсан зэргээс шалтгаалан багагүй шүүмжлэлд өртсөн юм. Тухайлбал гэрчийн гэр бүлийн гишүүд халдлагад өртөх, зарим гэрч худал мэлээлэл өгч бусдыг гүтгэх зэрэг сөрөг үзэгдэл гарах болсон байна.

1991 оны Италийн №82 хуульд “хуулийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа этгээдүүд, мөн тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалах” тухай хэм хэмжээг шинээр тусгасан. Тухайлбал энэ хуулийн 9 дүгээр зүйлд хэрэв мафитай тэмцэх ерөнхий комиссарын зөвшөөрсөн арга хэмжээ хангалттай бус гэж тооцвол, тусламжийн арга хэмжээг багтаасан хамгаалалтын тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхийг заасан юм. Улмаар Италийн №82 хуулийг 2001 онд шинэчлэн боловсруулсан байна. Үүнд орсон томоохон өөрчлөлт нь гэрч хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бие даасан бүтцийг бий болгосон бөгөөд дараах заалтыг шинээр тусгасан. Үүнд:

а/ хамгаалалтанд авах эрх бүхий хүнд:

1. мафи, мансууруулах бодистой холбоотой эсвэл хүн амины гэмт хэргийн гэрч, мэдээллэгч

2. 5-20 хүртлэх жилийн хорих ялаар шийтгүүлэхээр заасан гэмт хэргийн гэрч

3. Аюулд өртөж болзошгүй гэрч, мэдээлэгчийн ойр дотны хүмүүс

б/ Хамгаалалтын төрөл:

¹⁰⁸ Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 511 дэх тал.

¹⁰⁹ Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008., page 14.

<https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf>

1. "Түр зуурын төлөвлөгөө" (temporary plan)-ний дагуу амьдрах зардлыг оролцуулан 180 хоног өөр газарт нүүлгэн суурьшуулах

2. Нүүлгэн шилжүүлж буй хүмүүст зориулсан хамгаалах, нийгэмшүүлэх төлөвлөгөөний "Тусгай арга хэмжээ"

3. Нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан түр үнэмлэх бичиг баримт олгох, санхүүгийн болон хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх "Тусгай хамгаалах хөтөлбөр" хэрэгжүүлэх

с/ Хорих ял эдэлж буй мэдээлэгч, гэрчийг хамгаалалтанд авахад эдлэх ялын 4/1 ээс доошгүй хувийг эдэлсэн байх, эсхүл 10 буюу түүнээс дээш, бүх насаараа хорих ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн хэргээ өөрөө хүлээсэн байх шаардлагатай

d/ Төв комисс хамгаалалтанд авах талаар шийдвэр гаргахдаа дараах этгээдийн зөвшөөрлийг үндэслэнэ:

1. Дотоод яамны Төрийн нарийн бичгийн даргын орлогч

2. Хоёр шүүгчийн болон прокурор

3. Зохион байгуулалттай гэмт хэргийн чиглэлээр ажилладаг таван мэргэжилтний тодорхойлолт

e/Бичиг баримтын өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн бичиг баримтыг Төв комисс баталгаажуулна гэсэн заалтууд тус тус шинээр оржээ.

Тайланд улс

Гэрч хамгааллын тухай 2003 оны хууль батлагдаж гэрчийг нүүлгэн шилжүүлэх, байнгын хамгаалалтанд авах, иргэний бичиг баримтыг нь өөрчлөх зэрэг тусгай хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Уг хуулиар дараах төрлийн

гэмт хэргүүдэд дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд: хар тамхи худалдаалах; Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг; зохион байгуулалттай гэмт хэрэг; авилга, албан тушаалын гэмт хэрэг; мөнгө угаах; хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэх; хүн худалдаалах гэмт хэрэг болон ял шийтгэлийн доод хэмжээ нь 10 жилээс дээш байх гэмт хэргийн гэрчийг хамгаалалтад авахаар тус тус хуульчилсан байна.

Бусад улсын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтыг бий болгож, үүний үр дүнд гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн байна.

Манай орны хувьд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг олон нийтэд сурталчилхаас гадна шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, цагдаагийн алба, тахарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах зайлшгүй шаардлагатай. Мөн гэрч, хохирогчид туслалцаа үзүүлдэг мэргэжлийн байгууллагууд, нийгмийн бүлгүүдийн үүрэг, оролцоо тодорхой бус байгаа бөгөөд гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл систем үгүйлэгдэж байна.

2013 онд УИХ-аас батлан гаргасан “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулийн бодит хэрэгжилтийг хангах тусгай хөтөлбөрийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлснээр гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо үүсэх боломж бүрдэх юм.

Эцэст нь гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлэх нь хууль хэрэгжүүлэгчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараас ихээхэн хамаарах зүйл билээ.



Б.БЯМБАБААТАР
ХСИС-ийн Шүүхийн
шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн Харуул
хамгаалалтын
тэнхимийн ахлах
багш, хошууч

ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ЧИГ ХАНДЛАГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрх зүйн шинжлэх ухаанд “Цагдан хорих” ойлголтыг хэрхэн тодорхойлсныг манай орны зарим эрдэмтэн, судлаачдын ном зохиолоос авч үзэхэд: академич С.Нарангэрэл (латин-arrestum: англи- confinement under guard: орос-заключение под стражу) – эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэх мөрдөн байцаах, эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан шийдвэрлэх арга хэмжээний нэг¹¹⁰ юм гэж бичсэн байх бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлтэй холбон дэлгэрэнгүй байдлаар тайлбарласан байдаг.

Мөн хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугаацаагаар нийгмээс тусгаарлаж эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн”¹¹¹ гэж тодорхойлжээ.

¹¹⁰С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” 2дахь хэвлэл. УБ. 2008 он. 552 дахь тал

¹¹¹Б.Бат-Эрдэнэ. “МУ-ын ЭБШЭЗ-н Ерөнхий анги” УБ. 2004 он 265 дахь тал.